



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН  
СТАТИСТИКИЙН МЭДЭЭ  
2025 оны 1 дүгээр сар**

Улаанбаатар хот,  
2025 оны 02 сарын 10

**АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>4</b>
1.1. АЧАА ТЭЭВЭР.....	5
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР.....	6
<b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....</b>	<b>7</b>
2.1. АЧАА ТЭЭВЭР.....	7
2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР.....	9
2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ .....	11
<b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР.....</b>	<b>12</b>
3.1. АЧАА ТЭЭВЭР.....	12
3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР.....	14
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР.....</b>	<b>15</b>
4.1 АЧАА ТЭЭВЭР.....	15
4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	16
4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	16
4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	17
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ.....	18

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	4
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	7
Хүснэгт 3. Автотээврийн ачаа эргэлт.....	8
Хүснэгт 4. Автотээврийн ачааны нэр төрөл.....	9
Хүснэгт 5. Автотээврийн зорчигч.....	9
Хүснэгт 6. Хот хоорондын нийтийн тээврийн зорчигч.....	10
Хүснэгт 7. Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	10
Хүснэгт 8. Төмөр замын ачаа тээвэр.....	12
Хүснэгт 9. Төмөр замын зорчигч тээвэр.....	14
Хүснэгт 10. Агаарын тээврийн ачаа.....	15
Хүснэгт 11. Агаарын тээврийн зорчигч.....	15
Хүснэгт 12. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	16
Хүснэгт 13. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	17
Хүснэгт 14. Өнгөрөлт, буулт хөөрөлтийн тоо.....	17

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	5
Зураг 2. Нийт экспорт.....	5
Зураг 3. Нийт импорт.....	5
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	5
Зураг 5. Олон улсад зорчигч.....	6
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	6
Зураг 7. Автотээврийн ачаа.....	7
Зураг 8. Автотээврийн экспортын ачаа, боомтоор.....	7
Зураг 9. Автотээврийн импортын ачаа, боомтоор.....	8
Зураг 10. Ачаа эргэлт, боомтоор.....	8
Зураг 11. Ачааны нэр төрлөөр.....	9
Зураг 12. Автотээврийн зорчигч.....	9
Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	11
Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр.....	12
Зураг 15. Ачаа тээврийн байгууллагаар.....	12
Зураг 16. Ачаа тээврийн төрлөөр.....	13
Зураг 17. Дотоодын ачаа байгууллагаар.....	13
Зураг 18. Төмөр замын ачаа тээвэр, хоногоор.....	13
Зураг 19. Төмөр замын зорчигч тээвэр.....	14
Зураг 20. Төмөр замын зорчигч, хоногоор.....	14
Зураг 21. Агаарын тээврийн ачаа, шуудан.....	15
Зураг 22. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	15
Зураг 23. Ачаа шуудан, хоногоор.....	15
Зураг 24. Агаарын тээврийн зорчигч.....	16
Зураг 25. Олон улсын зорчигч тээвэр, агаарын тээвэрлэгчээр.....	17
Зураг 26. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	17
Зураг 27. Орон нутгийн зорчигч тээвэр, агаарын тээвэрлэгчээр.....	17
Зураг 28. Нислэгийн тоон үзүүлэлт.....	18

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2025 оны 1 дүгээр сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>1</sup>

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2023.01	2024.01	2025.01	Өсөлт бууралтын % 2025/2024
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	3,399.5	6,546.6	6,523.4	-0.4%
		Төмөр зам	мян.тн	2,923.3	3,603.4	3,786.5	5.1%
		Агаарын тээвэр	мян.тн	0.7	0.8	0.6	-17.7%
		<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>6,323.5</b>	<b>10,150.9</b>	<b>10,310.5</b>	1.6%
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	333.8	433.3	399.0	-7.9%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	988.4	902.0	1,031.1	14.3%
		Автотээвэр	мян.тн	3,340.2	6,381.6	6,331.6	-0.8%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>4,328.6</b>	<b>7,283.6</b>	<b>7,362.7</b>	1.1%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	298.0	357.4	345.6	-3.3%
		Автотээвэр	мян.тн	59.3	165.0	191.8	16.2%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>357.3</b>	<b>522.4</b>	<b>537.4</b>	2.9%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,303.1	1,910.8	2,010.7	5.2%
		Агаарын тээвэр	мян.тн	0.7	0.8	0.6	-17.7%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>1,303.8</b>	<b>1,911.5</b>	<b>2,011.3</b>	5.2%
6	Ачаа эргэлт (сая тонн/ км)	Автотээвэр	сая тн/км	578.9	1,080.8	1,057.8	-2.1%
		Төмөр зам	сая тн/км	1,553.2	1,746.8	1,778.0	1.8%
		Агаарын тээвэр	сая.тн/км	2.1	2.1	1.8	-14.5%
		<b>Нийт</b>	<b>сая тн/км</b>	<b>2,134.2</b>	<b>2,829.6</b>	<b>2,837.5</b>	0.3%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	10,566.3	11,203.7	10,969.4	-2.1%
		Төмөр зам	мян.хүн	154.9	165.0	157.0	-4.9%
		Агаарын тээвэр	мян.хүн	112.3	158.1	190.3	20.4%
		<b>Нийт зорчигч</b>	<b>мян.хүн</b>	<b>10,833.5</b>	<b>11,526.7</b>	<b>11,316.7</b>	-1.8%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	14.2	75.9	51.6	-32.1%
		Төмөр зам	мян.хүн	1.4	2.2	3.3	53.7%
		Агаарын тээвэр	мян.хүн	82.6	124.5	157.3	26.3%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>98.2</b>	<b>202.6</b>	<b>212.2</b>	4.7%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	124.4	139.0	148.8	7.1%
		Төмөр зам	мян.хүн	153.5	162.9	153.7	-5.6%
		Агаарын тээвэр	мян.хүн	29.7	33.5	32.9	-1.8%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>307.6</b>	<b>335.4</b>	<b>335.4</b>	0.01%
10	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн/ км	150.1	184.7	189.5	2.6%
		Төмөр зам	сая хүн/ км	48.8	68.2	67.3	-1.2%
		Агаарын тээвэр	сая хүн/ км	288.5	406.9	541.5	33.1%
		<b>Нийт</b>	<b>сая хүн/км</b>	<b>487.4</b>	<b>659.8</b>	<b>798.3</b>	21.0%
11	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	10,427.7	10,988.8	10,769.0	-2.0%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	624.0	885.0	1,115	26.0%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	512.0	626.0	628	0.3%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	2,109.0	5,020.0	6,410	27.7%
13	Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгсэл	Автовээвэр	ш	37,716.0	60,417.0	65,087.0	7.7%
14	Авто замын боомтуудаар орсон ачаатай тээврийн хэрэгсэл	Автовээвэр	ш	3,472.0	7,346.0	9,027.0	22.9%



<sup>1</sup> Зам, тээврийн салбарын 2025 оны 1 дүгээр сарын статистикийн мэдээг урьдчилсан гүйцэтгэлээр 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдөр гаргав.

### 1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 1 дүгээр сард 10.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6%-аар өссөн байна. Нийт ачаа тээврийн 63.27%-ийг автотээврээр, 36.72%-ийг төмөр замаар, 0.01%-ийг агаарын тээврээр тээвэрлэсэн байна.

- Автотээврээр 2025 оны 1 сард нийт 6.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс экспортын ачаа 6.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 0.8%-аар буурсан бол импортын ачаа 191.8 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2025 оны 1 сард нийт 3.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1%-аар өссөн байна. Үүнээс экспортын ачаа 1 сая тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 14.3%-аар, дотоодын ачаа 2 сая тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 5.2%-аар тус тус өссөн бол импортын ачаа 345.6 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 3.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 399.0 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 7.9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна
- Агаарын тээврээр 2025 оны 1 сард нийт 627.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 17.7%-аар буурлаа. Үүнээс ачаа тээвэр 609.6 тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 17.9%-аар, шуудан тээвэр 17.7 тонн болж өмнөх оны мөн үеэс 9.2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1. Нийт ачаа тээвэр, мян.тонн




Зураг 2. Нийт экспорт

2025 оны 1 дүгээр сарын экспортын хэмжээ 7.4 сая тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 1.1%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 1,031.1 мянган тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.3%-аар өссөн бол автотээврээр 6.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 0.8%-аар буурсан байна. Нийт экспортын дүнд автотээвэр 86%-ийг, төмөр зам 14%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 1 дүгээр сард нийт 537.4 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 2.9%-аар өссөн. Үүнээс автотээврээр 191.8 мянган тонн тээсэн нь 16.2%-аар өссөн бол төмөр замаар 345.6 мянган тонн тээвэрлэсэн нь өмнөх оны 1 дүгээр сараас 3.3%-аар буурсан байна. Нийт импортын дүнд төмөр замаар тээвэрлэсэн ачаа 64%, автотээврээр тээвэрлэсэн ачаа 36%-ийг эзэлж байна. /Зураг 3/

Зураг 3. Нийт импорт





## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2025 оны 1 дүгээр сард 11.3 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.8%-аар буурсан байна. 2025 онд зорчсон нийт зорчигчийн 97%-ийг автотээврээр, 1.3%-ийг төмөр замаар, 1.7%-ийг агаарын тээвэр тус тус эзэлж байна.

- Авто тээврээр 2025 оны 1 дүгээр сард 10.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 51.6 мянган зорчигч (-32.1%), орон нутагт 148.8 зорчигч (+7.1%), нийслэлийн нийтийн тээврээр 10.8 сая зорчигч (-2.0%) тус тус тээвэрлэсэн байна. Автотээврийн зорчигчийн 98%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.4%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.5%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- 2025 оны 1 дүгээр сард төмөр замаар нийт 157 мянган зорчигч зорчсоноор өмнөх оны мөн үеэс 4.9%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 3.3 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 53.7%-аар өссөн бол орон нутагт 153.7 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 5.6%-аар бууржээ.
- 2025 оны 1 дүгээр сард агаарын тээврээр нийт 190.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 20.4%-аар өсжээ. Үүнээс олон улсад 157.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 26.3%-аар өссөн бол орон нутагт 32.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 1.8%-аар буурсан байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн



Зураг 5. Олон улсад зорчигч


- Автотээвэр
- Төмөр зам
- Агаарын тээвэр

2025 оны 1 дүгээр сард олон улсад нийт 212.2 мянган зорчигч (+4.7%) зорчсон нь агаарын тээврээр 157.3 мянган зорчигч (+26.3%), автотээврээр 51.6 мянган зорчигч (-32.1%), төмөр замаар 3.3 мянган зорчигч (+53.7%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 74%, автотээвэр 24%, төмөр зам 2%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны 1 дүгээр сард орон нутагт нийт 335.4 мянган зорчигч (+0.01%) зорчсон нь автотээврээр 148.8 мянган зорчигч (+7.1%), төмөр замаар 153.7 мянган зорчигч (-5.6%), агаарын тээврээр 32.9 мянган зорчигч (-1.8%) тус тус зорчсон байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 10%, автотээвэр 45.5%, төмөр зам 44.5%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутагт зорчигч

- Автотээвэр
- Төмөр зам
- Агаарын тээвэр



**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**

**2.1. АЧАА ТЭЭВЭР<sup>2</sup>**


Хүснэгт 2

Ачаа тээвэр, боомтуудаар	2024 оны 1 сар		2025 оны 1 сар	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
<b>Нийт ачаа, тонн</b>	<b>165,038.1</b>	<b>6,381,610.9</b>	<b>191,766.0</b>	<b>6,331,632.0</b>
ОХУ	30,647.7	3,798.1	16,931.0	6,275.0
Алтанбулаг	13,330.9	3,798.1	11,622.0	6,275.0
Боршоо	5,119.8	0.0	3,829.0	0.0
Цагаан нуур	12,197.0	0.0	1,480.0	0.0
БНХАУ	134,390.4	6,377,812.8	174,835.0	6,325,357.0
Бичигт	619.0	226,006.0	0.0	638,526.0
Баянхошуу	0.0	44,601.6	0.0	35,343.0
Бургастай	0.0	61,031.0	0.0	29,742.0
Булган	0.0	249,776.0	0.0	174,926.0
Гашуунсухайт	9,120.0	3,599,243.5	10,720.0	3,581,268.0
Замын-Үүд	117,033.5	83,510.0	154,817.0	64,007.0
Ханги	1,725.0	648,732.7	450.0	551,513.0
Хавирга	92.9	0.0	2,848.0	16,934.0
Шивээ хүрэн	5,800.0	1,464,912.0	6,000.0	1,233,098.0
Сүмбэр	0.0	0.0	0.0	0.0
<b>Нийт ачаа тээвэр</b>	<b>6,546,648.9</b>		<b>6,523,398.0</b>	

2025 оны 1 сард нийт 6.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс экспортын ачаа 6.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 0.8%-аар буурсан бол импортын ачаа 191.8 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өссөн байна.

2025 оны 1 сарын нийт ачаа тээврийн 6.3 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 191.8 мянган тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. /Зураг 7/

**Зураг 7. Автотээврийн ачаа**



**Зураг 8. Экспортын ачаа, боомтоор**



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтуудаар 6.3 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оны мөн үеэс 65.2%-аар өсжээ. Харин БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар 6.3 сая тонн ачаа гарсан байна.

Үүнээс хамгийн их ачаа Гашуунсухайт боомтоор 3.6 сая тонн (-0.5%), Шивээхүрэн боомтоор 1.2 сая тонн (-15.8%), Ханги боомтоор 551.5 мянган тонн (-15.0%), Булган боомтоор 174.9 мянган тонн (-30.0%), Бичигт боомтоор 638.5 мянган тонн (\*2.8), Замын-Үүд боомтоор 64.0 мянган тонн (-23.4%), Бургастай боомтоор 29.7 мянган тонн (-51.3%), Баянхошуу боомтоор 35.3 мянган тонн (-20.8%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 8/

<sup>2</sup> "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

Импортын ачаа тээвэр 1 дүгээр сард 191.8 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.2%-аар өссөн байна. Үүнээс БНХАУ-аас 174.8 мянган тонн буюу нийт импортын ачааны 91%, ОХУ-аас 16.9 мянган тонн буюу нийт импортын ачааны 9%-ийг тус тус оруулж ирсэн байна.

БНХАУ-аас Замын-Үүд боомтоор 154.8 мянган тонн ачаа (+32.3%), Гашуунсухайт боомтоор 10.7 мянган тонн (+17.5%), Шивээхүрэн боомтоор 6.0 мянган тонн (+3.4%), Хавирга боомтоор 2.8 тонн ачаа, ОХУ-аас Алтанбулаг боомтоор 11.6 мянган тонн (-44.8%), Цагааннуур боомтоор 1.5 мянган тонн (-87.9%), Боршоо боомтоор 3.8 мянган тонн (-25.2%) ачаа тус тус орж иржээ. /Зураг 9/

Зураг 9. Импортын ачаа, боомтоор



Ачаа эргэлт, боомтоор	Хэмжих нэгж	Хүснэгт 3		Өсөлт бууралтын %
		2024.01	2025.01	
Нийт ачаа эргэлт	тн.км	1,080,783,739.9	1,057,780,765.0	-2.1%
Алтанбулаг	тн.км	393,965.9	411,631.0	4.5%
Бичигт	тн.км	18,130,000.0	51,082,080.0	181.8%
Баянхошуу	тн.км	28,545,024.0	22,619,520.0	-20.8%
Бургастай	тн.км	4,882,480.0	2,379,360.0	-51.3%
Гашуунсухайт	тн.км	829,923,605.0	826,157,240.0	-0.5%
Замын-Үүд	тн.км	1,403,804.5	1,531,768.0	9.1%
Цагаан нуур	тн.км	1,219,700.0	148,000.0	-87.9%
Ханги	тн.км	13,009,154.0	11,039,260.0	-15.1%
Шивээ хүрэн	тн.км	95,596,280.0	80,541,370.0	-15.7%
Хавирга	тн.км	2,136.6	454,986.0	21195.0%
Булган	тн.км	87,421,600.0	61,224,100.0	-30.0%
Боршоо	тн.км	255,990.0	191,450.0	-25.2%

2025 оны 1 дүгээр сард автотээврийн ачаа эргэлт 1,057.8 сая тн.км болж өмнөх оны мөн үеэс 2.1%-аар буурсан байна.

Зураг 10. Ачаа эргэлт, боомтоор





Зураг 11. Ачааны нэр төрлөөр



Хүснэгт 4

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
Нүүрс	тонн	6,182,427.7	6,120,204.8	-1.0%
Газрын тос	тонн	44,601.6	35,343.5	-20.8%
Зэсийн баяжмал	тонн	69,707.1	78,174.8	12.1%
Төмрийн хүдэр	тонн	61,739.6	35,568.5	-42.4%
Жонш	тонн	11,609.9	45,206.0	289.4%
Цайр	тонн	0.0	0.0	
Бусад	тонн	11,525.0	17,134.4	48.7%


Авто замын боомтуудаар гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 6.1 сая тонн (-1.0%), зэсийн баяжмал 78.2 мянган тонн (+12.1%), жонш 45.2 мянган тонн (+289.4%), төмрийн хүдэр 35.6 мянган тонн (-42.4%), газрын тос 35.3 мянган тонн (-20.8%), бусад 17.1 мянган тонн (+48.7%) ачаа тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 11/

## 2.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 5

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Нийт зорчигч тээвэр</b>	хүн	11,203,658.0	10,969,449.0	-2.1%
Олон улсад зорчигчид	хүн	75,919.0	51,573.0	-32.1%
Хот хоорондын зорчигч	хүн	138,988.0	148,833.0	7.1%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	10,988,751.0	10,769,043.0	-2.0%
Зорчигч эргэлт	сая хүн.км	184.7	189.5	2.6%

Зураг 12. Зорчигч тээвэр



Авто тээврээр 2025 оны 1 дүгээр сард 10.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 2.1%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 51.6 мянган зорчигч (-32.1%), орон нутагт 148.8 зорчигч (+7.1%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 10.8 сая зорчигч (-2.0%) тус тус зорчсон байна. Автотээврийн зорчигчийн 98%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.4%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.5%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 12/

## Зам, тээврийн салбарын статистикийн мэдээ – 2025 оны 1 дүгээр сар

Хүснэгт 6

№	Аймгийн нэр	№	Сум дүүргийн нэр	Тээвэрлэлийн зай	Тээврийн хэрэгслийн төрөл	2025 оны 1- сар				
						Суудал ашиглалт	Рейс	Зорчигч		
								УБ-аас гарсан	ОН-аас ирсэн	Бүгд
1	Архангай аймаг	1	Цэцэрлэг	560	том оврын	48.3	2	50	37	87
		2	Эрдэнэбулган	498	том оврын	68.3	93.5	2873	2831	5704
		3	Тариат	647	том оврын	24.7	4.5	64	34	98
		4	Жаргалант	571	том оврын	81.8	4.5	172	152	324
		5	Эрдэнэмандал	511	том оврын	55.6	3	73	77	150
2	Баян-Өлгий аймаг	6	Өлгий-сум	1709	том оврын	82	69	1959	3022	4981
3	Баянхонгор аймаг	7	Баянхонгор	640	том оврын	85.5	122	4371	4807	9178
4	Булган аймаг	8	Булган	438	том оврын	68	31	844	1053	1897
5	Говь-Алтай аймаг	9	Есөнбулаг	1037	том оврын	86.6	68	2404	2779	5183
		10	Бигэр	1247	том оврын	0	0	0	0	0
6	Дархан-Уул аймаг	11	Дархан	219	том оврын	53.6	249.5	6452	5595	12047
		12		суудлын	94.5	156	560	619	1179	
		13	Шарын гол	279	том оврын	0	0	0	0	0
7	Дорнод аймаг	14	Баян-Уул	600	том оврын	63.92	4	513	486	999
		15	Хэрлэн сум	658	том оврын	84.1	87	3554	3847	7401
8	Дундговь аймаг	16	Эрдэнэдалай	375	том оврын					0
		17	Сайхан Овоо	505	том оврын					0
9	Завхан аймаг	18	Улиастай	1023	том оврын	90.1	63.5	2346	2690	5036
		19	Тосонцэнгэл	838	том оврын	86.7	32.5	1156	1325	2481
		20	Тэс	1114	том оврын	86.1	9	366	316	682
		21	Отгон	1037	том оврын	93.7	4.5	204	167	371
10	Орхон аймаг	22	Баян-Өндөр	378	том оврын	70.9	187	5873	6021	11894
		23		суудлын	80.6	195.5	525	735	1260	
11	Өвөрхангай аймаг	24	Арвайхээр	431	том оврын	53.2	122	2602	3204	5806
		25	Хужирт	384	том оврын	43.9	21	517	313	830
		26	Хархорин	365	том оврын	59	30	683	910	1593
		27	Сант	409	том оврын	67.2	4.5	187	85	272
		28	Бат-Өлзий	433	том оврын	69	18	479	638	1117
12	Өмнөговь аймаг	29	Даланзадгад	575	том оврын	61.5	30	779	881	1660
		30	Цогтцэций	544	том оврын	77.3	123	4548	3918	8466
		31	Цагаанхад	933	том оврын	72.3	30.5	1077	863	1940
13	Дорноговь аймаг	32	Сайншанд	450	том оврын	72.82	31	1084	941	2025
		33	Замын-Үүд	660	том оврын					0
14	Сүхбаатар аймаг	34	Баруун-Урт	565	том оврын	77.66	61	1974	2214	4188
		35	Дарьганга	710	том оврын	70.45	4	93	155	248
		36	Эрдэнэцагаан	768	том оврын	63.01	9	255	244	499
15	Сэлэнгэ аймаг	37	Сүхбаатар	343	том оврын	86.4	32.5	1280	1191	2471
16	Төв аймаг	38	Борнуур	102	дунд оврын	0	0	0	0	0
		39	Зуунмод	43	дунд оврын	61.5	341.5	2347	2447	4794
		40	Батсүмбэр	79	дунд оврын	0	0	0	0	0
		41	Жаргалант	128	дунд оврын	36.9	29	263	107	370
17	Ховд аймаг	42	Хо.Жаргалант	1488	том оврын	74.4	102.5	2852	3748	6600
		43	Хо.Булган	1720	том оврын	68.4	19.5	490	684	1174
18	Хэнтий аймаг	44	Өндөрхаан	338	том оврын	75.99	62	2003	2237	4240
		45	Хэ.Батноров	443	том оврын					0
19	Хөвсгөл аймаг	46	Мөрөн	788	том оврын	81.5	206	6690	8175	14865
		47	Галт	920	дунд оврын	94.3	4	158	174	332
20	Увс аймаг	48	Улаангом	1382	том оврын	80.3	124	3667	4745	8412
		49	Ув.Өмнөговь	1367	том оврын	88.1	4.5	181	168	349
		50	Өндөрхангай	1165	том оврын	82.5	5	161	202	363
		51	Зүүнговь	1280	том оврын	90.2	5	186	211	397
21	ОХУ	52	Улан-Үд	600	том оврын	27.8	39.5	532	435	967
22	БНХАУ	53	Эрээн	676	том оврын	73.92	60	2153	1750	3903
Нийт дүн				35,918			2905	71600	77233	148833

2025 оны 1 сард автотээврээр зорчсон зорчигчийн тоог дэлгэрэнгүй байдлаар дээрх хүснэгтэд харуулав. Аймгуудаар авч үзвэл Хөвсгөл аймагруу 15.2 мянган зорчигч, Дархан-Уул болон Орхон аймагруу тус бүр 13.2 зорчигч, Өмнөговь аймагруу 12.1 мянга, Өвөрхангай аймагруу 9.6 мянга, Увс аймагруу 9.5 мянган зорчигч, Баянхонгор аймагруу 9.2 мянга, Завхан аймагруу 8.6 мянга, Дорнод аймагруу 8.4 мянга, Ховд аймагруу 7.8 мянга, Архангай аймагруу 6.4 мянга, Төв болон Говь-Алтай аймагруу тус бүр 5.2 мянга, Баян-Өлгий болон Сүхбаатар аймагруу 4.9 мянга, Хэнтий аймагруу 4.2 мянга, Сэлэнгэ аймагруу 2.5 мянга, Дорноговь аймагруу 2 мянга, Булган аймагруу 1.9 мянган зорчигч тус бүр ирж очсон байна. <sup>3</sup>


<sup>3</sup> "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

**2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ**

Хүснэгт 7

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Орсон тээврийн хэрэгсэл</b>	7,346	9,027	22.9%
БНХАУ-аас	5,428	7,919	45.9%
Гашуунсухайт	228.0	268.0	17.5%
Шивээхүрэн	145.0	150.0	3.4%
Замын-Үүд	4,980.0	7,422.0	49.0%
Ханги	69.0	18.0	-73.9%
Хавирга	6.0	61.0	916.7%
ОХУ-аас	1,918	1,108	-42.2%
Алтанбулаг	871.0	789.0	-9.4%
Боршоо	227.0	171.0	-24.7%
Цагааннуур	820.0	148.0	-82.0%
<b>Гарсан тээврийн хэрэгсэл</b>	60,417	65,087	7.7%
БНХАУ-руу	58,754	49,939	-15.0%
Бичигт	3,087.0	6,055.0	96.1%
Баянхошуу	1,275.0	999.0	-21.6%
Булган	3,415.0	2,458.0	-28.0%
Бургастай	2,011.0	491.0	-75.6%
Гашуунсухайт	25,196.0	26,072.0	3.5%
Шивээхүрэн	14,588.0	8,540.0	-41.5%
Замын-Үүд	1,363.0	970.0	-28.8%
Ханги	7,819.0	4,208.0	-46.2%
Хавирга	0.0	146.0	-
ОХУ-руу	1,663	15,148	810.9%
Алтанбулаг	738.0	14,983.0	1930.2%
Боршоо	227.0	165.0	-27.3%
Цагааннуур	698.0	0.0	-100.0%

**Зураг 13. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл**



Монгол Улсын авто замын боомтуудаар 1 дүгээр сард нийт 74,114 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс 9,027 тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны мөн үеэс 22.9%, 65,087 тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны мөн үеэс 7.7%-аар тус тус өссөн байна. Гашуунсухайт боомтоор 26,072 ачаатай тээврийн хэрэгсэл хамгийн их гарсан бол Замын-Үүд боомтоор 7,422 ачаатай тээврийн хэрэгсэл хамгийн ихээр орсон байна. /Хүснэгт 5, Зураг 13/

**БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР**


**3.1. АЧАА ТЭЭВЭР**

Хүснэгт 8


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Ачаа тээвэрлэлт</b>	<b>мян.тн</b>	3,603.4	3,786.5	5.1%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,947.2	2,947.8	0.02%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	135.5	184.8	36.4%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	171.1	225.0	31.5%
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	312.5	308.7	-1.2%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	37.2	120.2	223.4%
Дотоодын ачаа	мян.тн	1,910.8	2,010.7	5.2%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	1,254.5	1,172.0	-6.6%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	135.5	184.8	36.4%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	171.1	225.0	31.5%
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	312.5	308.7	-1.2%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	37.2	120.2	223.4%
Импорт ачаа	мян.тн	357.4	345.6	-3.3%
Экспорт ачаа	мян.тн	902.0	1,031.1	14.3%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	433.3	399.0	-7.9%
Нийт ачаа эргэлт	сая тн.км	1,746.8	1,778.0	1.8%

Төмөр замын тээврээр 2025 оны 1 сард нийт 3.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1%-аар өссөн байна. Үүнээс экспортын ачаа 1,031.1 мянган тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 14.3%-аар, дотоодын ачаа 2 сая тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 5.2%-аар тус тус өссөн бол импортын ачаа 345.6 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 3.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 399.0 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 7.9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт ачаа эргэлт 1,788.0 сая тн.км болж өмнөх оны мөн үеэс 1.8%-аар өссөн байна. /Хүснэгт 7, Зураг 14/

**Зураг 14. Төмөр замын ачаа тээвэр, мян.тн**





**Зураг 15. Ачаа тээвэр, байгууллагаар**



Нийт ачаа тээврийн 2.9 сая тонн буюу 78%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 308.7 мянган тонн буюу 8%-ийн ачааг "Монголиантранс Ложистик" ХХК, 225.0 мянган тонн буюу 6%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 184.8 мянган тонн буюу 5%-ийн ачааг "Монголын төмөр зам" ТӨХК, 120.2 мянган тонн буюу 3%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 15/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 2 сая тонн буюу 53%-ийг дотоодын ачаа, 1031.1 мянган тонн буюу 27%-ийг экспортын ачаа, 399.0 мянган тонн буюу 11%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 345.6 мянган тонн буюу 9%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 16/

Зураг 16. Ачаа тээврийн төрөл




Зураг 17. Дотоодын ачаа, байгууллагаар

- "Улаанбаатар төмөр зам" ХНН
- "Монголын төмөр зам" ТӨХК
- "Тавантолгой төмөр зам" ХХК
- "Монголиантранс Ложистик" ХХК
- "Монголиантранс Лайн" ХХК

Дотоодод тээвэрлэсэн 2 сая тонн ачааны 1.2 сая тонн ачаа буюу 58%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 308.7 мянган тонн ачаа буюу 16%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 225.0 мянган тонн буюу 11%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 184.8 мянган тонн ачаа буюу 9%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 120.2 мянган тонн буюу 6%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 17/

Зураг 18. Төмөр замын ачаа тээвэр, хоногээр




2025.01.01-2025.01.31-ний өдрүүдийн төмөр замын ачаа тээврийн хоногийн мэдээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. Үүнд "Улаанбаатар төмөр зам" ХНН, "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой Төмөр зам" ХХК, "Монголиантранс Ложистик" ХХК, "Монголиантранс Лайн" ХХК-иудын ачаа тээврийн хоногийн мэдээг нэгтгэн оруулав. Эхний сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 122 мянган ачаа тээвэрлэж байна. /Зураг 18/

3.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Хүснэгт 9

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022.01	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Зорчигч тээвэрлэлт</b>	<b>мян.хүн</b>	<b>154.9</b>	<b>165.0</b>	<b>157.0</b>	<b>-4.9%</b>
Олон улс	мян.хүн	1.4	2.2	3.3	53.7%
Орон нутаг	мян.хүн	153.5	162.9	153.7	-5.6%
Зорчигч эргэлт	сая. хүн км	48.8	68.2	67.3	-1.2%



2025 оны 1 дүгээр сард төмөр замаар нийт 157 мянган зорчигч зорчсоноор өмнөх оны мөн үеэс 4.9%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 3.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 53.7%-аар өссөн бол орон нутагт 153.7 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 5.6%-аар бууржээ. Зорчигч эргэлт 67.3 сая хүн км болж 1.2%-аар буурлаа. /Зураг 19/

**Зураг 20. Төмөр замын зорчигч, хоногоор**




2025.01.01-2025.01.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. 2025 оны эхний сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 5 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 20/

**БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР**  
**4.1 АЧАА ТЭЭВЭР**

Хүснэгт 10

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Нийт ачаа, шуудан тээвэр</b>	тн	762.3	627.32	-17.7%
олон улсад	тн	759.6	625.52	-17.7%
орон нутагт	тн	2.65	1.80	-32.1%
<b>Нийт ачаа</b>	тн	742.8	609.58	-17.9%
олон улсад	тн	740.1	607.78	-17.9%
орон нутагт	тн	2.64	1.80	-31.8%
<b>Нийт шуудан</b>	тн	19.54	17.74	-9.2%
олон улсад	тн	19.53	17.74	-9.2%
орон нутагт	тн	0.01	0.00	-100.0%
Ачаа, шуудан эргэлт	мян.тн.км	2,064.0	1,763.8	-14.5%




**Зураг 21. Ачаа, шуудан**


Агаарын тээврээр 2025 оны 1 сард нийт 627.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 17.7%-аар буурлаа. Үүнээс ачаа тээвэр 609.6 тонн болж өмнөх оны 1 дүгээр сараас 17.9%-аар, шуудан тээвэр 17.7 тонн болж өмнөх оны мөн үеэс 9.2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Нийт ачаа шуудангийн 97.2%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.8%-ийг шуудан эзэлж байна. /Зураг 21/ Ачаа, шуудан эргэлт 14.5%-аар буурсан байна.

Олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 625.5 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 17.7%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 1.8 тонн болж өмнөх оны мөн үеэс 32.1%-аар тус тус буурсан байна.

2025 оны оны 1 дүгээр сард агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачааны 99.7%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.3%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. /Зураг 22/



**Зураг 22. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан**




**Зураг 23. Ачаа шуудан, тонн /хоног**

#### 4.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Хүснэгт 11

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Нийт зорчигч тээвэр</b>	<b>Хүн</b>	<b>158,078</b>	<b>190,264</b>	<b>20.4%</b>
олон улсад	Хүн	124,530	157,332	26.3%
орон нутагт	Хүн	33,548	32,932	-1.8%
Зорчигч эргэлт	сая хүн.км	406.9	541.5	33.1%



2025 оны 1 дүгээр сард агаарын тээврээр нийт 190.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 20.4%-аар өсжээ. Үүнээс олон улсад 157.3 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 26.3%-аар өссөн бол орон нутагт 32.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 1.8%-аар буурсан байна. /Хүснэгт 10/

2025 оны 1 дүгээр сард агаарын тээврээр зорчигчдын 82.7% нь олон улсад зорчсон бол 17.3% нь орон нутагт зорчсон байна. /Зураг 24/

Зорчигч эргэлт 541.5 сая хүн км болж өмнөх оны мөн үеэс 33.1%-аар өссөн байна.

#### 4.2.1. ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Хүснэгт 12

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Олон улсын зорчигч тээвэр</b>	<b>хүн</b>	<b>124,530</b>	<b>157,332</b>	<b>26.3%</b>
Сөүл	хүн	36,226	41,515	14.6%
Бээжин	хүн	20,613	23,186	12.5%
Фукуок	хүн	10,350	12,411	19.9%
Истанбул	хүн	9,349	10,753	15.0%
Токио	хүн	7,941	10,522	32.5%
ХонКонг	хүн	7,588	9,408	24.0%
Бангкок	хүн	5,146	6,503	26.4%
Хөх хот	хүн	3,511	5,548	58.0%
Пукет	хүн	4,783	5,396	15.7%
Франкфурт	хүн	4,750	5,212	9.7%
Хо Ши Мин	хүн	1,695	4,915	190.0%
Санья/Хайнань	хүн	1,918	4,518	135.6%
На Транг	хүн	334	2,966	788.0%
Бусан	хүн	2,102	2,680	27.5%
Бусад	хүн	8,224	11,661	41.8%

2025 оны 1 дүгээр сард агаарын тээврээр олон улсад нийт 157.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 26.3%-аар өссөн. Үүнээс Сөүл чиглэлд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд 26.4% буюу 41.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 14.6%-аар өсжээ. Бээжин чиглэлд 14.7% буюу 23.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 12.5%-аар, Фукуок чиглэлд 7.9% буюу 12.4 мянган зорчигч зорчсон нь 19.9%-аар тус тус өслөө. Мөн бусад чиглэлд зорчсон зорчигчийн тоо нэмэгдсээр байна. Хамгийн их өсөлт үзүүлсэн чиглэл нь На Транг чиглэлд 2.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9 дахин өсжээ.



**Зураг 25. Олон улсын зорчигч /агаарын тээвэрлэгчээр/**



Мөн олон улсад зорчсон зорчигчдын хамгийн өндөр буюу үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр 77.2 мянган зорчигч буюу 49% нь ниссэн бол “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 17.4 мянга буюу 11%, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 15 мянга буюу 9%, Айрчайна нислэгээр 13.8 мянга буюу 9%, “Korean Air”-ийн нислэгээр 12.7 мянга буюу 8%, Туркиш айрлайнс нислэгээр 5.5 мянга буюу 3%, Ашиана айрлайнс нислэгээр 4.5 мянга буюу 3%, Жежү айр нислэгээр 2.9 мянга буюу 2%, Ираеро нислэгээр 1 мянга буюу 1%, бусад агаарын тээвэрлэгчийн нислэгээр 7.3 мянган зорчигч буюу 5% нь зорчсон байна. /Зураг 25/

**4.2.2. ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР**

Хүснэгт 13

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Орон нутгийн зорчигч тээвэр</b>	Хүн	33,548	32,932	-1.8%
Ховд	хүн	846	1,141	34.9%
Өлгий	хүн	601	1,161	93.2%
Улаангом	хүн	120	499	315.8%
Алтай	хүн	567	588	3.7%
Оюутолгой	хүн	29,608	28,451	-3.9%
Мөрөн	хүн	103	539	423.3%
Улиастай	хүн	470	553	17.7%
Бусад	хүн	1,233	-	-


**Зураг 26. Орон нутгийн зорчигч, чиглэлээр**



2025 оны 01 дүгээр сард агаарын тээврээр орон нутагт зорчигчдын 87.1% буюу 28.5 мянган зорчигч Оюутолгой чиглэлд зорчсон нь өмнөх оноос 3.9%-аар буурсан. Улаангом, Мөрөн, Өлгий чиглэлд зорчигчийн тоо өмнөх оны мөн үеэс 2-4 дахин нэмэгджээ. /Зураг 26/

Орон нутагт зорчигчдын 66% буюу 21.8 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 24% буюу 7.7 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 10% буюу 3.4 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. /Зураг 27/

**Зураг 27. Олон нутгийн зорчигч /агаарын тээвэрлэгчээр/**



4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 14

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01	2025.01	Өсөлт, бууралтын %
<b>Нийт нислэгийн тоо</b>	<b>ш</b>	6,531	8,153	24.8%
Өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	5,020	6,410	27.7%
Хөөрөлт, буулт	ш	1,511	1,743	15.4%
үүнээс:				
Олон улс	ш	885	1,115	26.0%
Орон нутаг	ш	626	628	0.3%

2025 оны 1 дүгээр сард нийт нислэгийн тоо 8,153 болж өмнөх оны мөн үеэс 24.8%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 6,410 болж өмнөх оны мөн үеэс 27.7%-аар, олон улсын хөөрөлт, буулт 1,115 болж 26%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 628 болж өмнөх оны мөн үеэс 0.3%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 13/

Зураг 28. Нислэгийн тоон үзүүлэлт

